

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.29 №43 (43)

ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГА ЦЭРГИЙН ДЭЭД ЦОЛ ХҮРТЭЭХ ТУХАЙ ЗАРЛИГ ГАРГАЛАА

Монгол Улсад генерал цол олгож эхэлсний 77 жилийн ой, “Монгол генералын өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга цэргийн дээд цол хүртээх тухай зарлиг гаргажээ.

“ХОШУУЧ ГЕНЕРАЛ” ЦОЛЫГ:

- Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Бригадын генерал Гомбожавын Ариунбуян,
- Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Бужийновын Амгаланбаатар,
- Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал Очирын Энхбаяр.

“БРИГАДЫН ГЕНЕРАЛ” ЦОЛЫГ:

- Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Дагвадоржийн Ганхуяг,

- ЗХЖШ-ын Нэгдүгээр орлогч дарга, хурандаа Цэвэлмаагийн Жавхланбаатар,
- Дотоодын цэргийн штабын дарга, хурандаа Сийлээгийн Ганбат,
- Хил хамгаалах ерөнхий газрын Ар тал, зэвсэглэл, инженер техник эрхэлсэн дэд дарга, хурандаа Дашдондогийн Ганбаатар,
- Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Батмөнхийн Ууганбаяр,
- ЗХЖШ-ын Материал техникийн газрын дарга, хурандаа Маждаагийн Мөнхбаяр,
- Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, хурандаа Балжидын Баатар,
- Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч, хурандаа Дашцэдэнгийн Баасандамба,
- Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга, хурандаа Батсуурийн Эрдэнэбат,
- ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа Дамдинсүрэнгийн Дамдинцэрэн нарт тус тус хүртээв.



ҮЙЛ ЯВДАЛ

РОТ /БАТАРЕЙ/, САЛААНЫ ЗАХИРАГЧ НАРЫН ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙНА

Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын өгсөн үүргийн дагуу Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын рот /батареј/, салааны захирагч нарын зөвлөгөөн энэ сарын 28-29-ний өдрүүдэд “Зөв төлөвшил, зөв хүмүүжил” сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж байна.

Зөвлөгөөнийг хоёр үе шаттай явуулах бөгөөд нэгдүгээр үе шатыг нэгтгэл, анги, байгууллагууд дотооддоо заагдсан хөтөлбөрийн дагуу явуулж байгаа бол хоёрдугаар үе шат нь ирэх сарын 26, 27-ны өдрүүдэд явагдах юм. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын салаа, салбарын офицеруудын цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, удирдан явуулах, заах арга зүйг сайжруулах, дүрмийн дагуу цэргийн алба хаагчидтай харьцах, өөрийн удирдлагад

байгаа захирагдагсдаа сурган хүмүүжүүлж, эх оронч, үндэсний үзэлтэй зөв иргэн хүн болгон төлөвшүүлэхэд энэхүү зөвлөгөөний зорилго оршиж байгаа юм.

Зөвлөгөөн эх оронч, үндэсний үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх арга зам, цэргийн сургалт бэлтгэлд тэргүүний туршлагыг нэвтрүүлэх арга зам, цэргийн алба хаагчдын сэтгэл зүй, ёс суртахууны өнөөгийн байдал, цэргийн албанд дагаж мөрдөх хууль, эрх зүй, цэргийн алба хаагчдыг сурган хүмүүжүүлэх онцлог, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам зэрэг сэдвийн хүрээнд явагдаж байна. Ингэхдээ “Монгол бахархал, монгол хүн байхын учир”, “Нийгмийн харилцаа ба цэргийн алба хаагчийн ёс зүй”,

“Офицер, ахлагчийн хувийн хүмүүжил, нэр хүндийн асуудал”, “Хүний эрх болон цэргийн алба хаагчдын хуулиар хязгаарлагдсан эрхийн талаарх ойлголт”, “Тасаг, бүлгийн дарга нарыг сурган хүмүүжүүлэх арга зүй, хүнтэй ажиллах арга барил эзэмших нь”, “Цэргийн алба хаагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлүүд, тэдгээрийг бууруулах арга зам”, “Архи, тамхины хор уршиг, түүнээс гарч болох сөрөг хүчин зүйлс”, “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг” зэрэг олон сэдвээр харилцан ярилцаж байгаа юм.

Тус зөвлөгөөн нэгтгэл, анги тус бүрт нэгэн зэрэг явагдаж байгаа ба цар тахлаас урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжийг баримтлан зохион байгуулагдаж байна.

Д.Ганзориг: ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧДЫН ТӨЛӨВШИЛ САЛБАРЫН ОФИЦЕРУУДААС ИХЭЭХЭН ХАМААРНА



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын рот (батареј), салааны захирагч нарын зөвлөгөөн энэ цаг үед явагдаж байна. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг өчигдөр оролцогчдод хандаж, цахимаар үүрэг, чиглэл өгч,

ажлын амжилт хүслээ.

Хошууч генерал Д.Ганзориг “Юуны өмнө Монгол Улсад генерал цол үүсэн бий болсны 77 жилийн ойн баярын мэндийг рот, салааны захирагч нартаа хүргэе. Яагаад та нарт генерал цолтны



баяр хүргэж байна гэхээр та нарын дунд ирээдүйд Зэвсэгт хүчнээ удирдаж, генерал хэмээх эрхэм цолны эзэн болох цэргийн алба хаагчид байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
5	-2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
26	13

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.419.00	3.478.00
CNY	437.50	441.20
RUB	37.50	39.10
JPY	26.13	26.63
KRW	2.47	2.60

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 18
2021.04.29.
/ПҮРЭВ ГАРАГ/

ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ САРЫН ЗУРГААН ЦАГААН УЛААГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Эд малын гарлагатай.

Наран ургах, шингэх:

05.38-20.02

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Суудал:

Хий.

Аргын тооллын 4 дүгээр сарын 29, Бархасвадь гараг. Билгийн тооллын 18, Онцгой одтой, улаагчин хонь өдөр. Өдрийн наран 5 цаг 38 минутад мандан, 20 цаг 02 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адуус номхруулах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, хийморийн дарцаг хатгахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

32.437+1171

ЭДГЭРСЭН

18.033

НАС БАРСАН

97/8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

1955 (22)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

285

ЭДГЭРСЭН

1648

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 147,539,302

Эдгэрсэн

Нийт: 127,450,971

Нас барсан

Нийт: 3,116,444

ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	58,805
НИЙТ	1,007,030
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/	
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	11,381
НИЙТ	2,675,590
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО	
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	2,078
НИЙТ	376,425
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН	
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	391
НИЙТ	66,267

2021.04.28

11:00 ЦАГ ИЙН БААДАР

ХАВРАГА ДАВНА

ЗАСГИЙН ГАЗАР

ЦАР ТАХЛЫН ЧИГЛЭЛЭЭР 14 СУДАЛГАА ХИЙГДЭЖ БАЙНА

Засгийн газрын ээлжит хуралдаан өчигдөр болж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

“Таван толгойн ордыг ашиглах үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолыг батлав. Тогтоолд Таван толгойн үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтад багтаж буй төслүүд, нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу энэ оны гуравдугаар улиралд багтаан эхлүүлж, гүйцэтгэлийг эрчимжүүлэхийг холбогдох сайд нарт үүрэг болголоо. Тавантолгойн ордын нүүрсийг нэмүү өртөг шингээн баяжуулж, эрдэс баялгийн боловсруулалтын түвшинг дээшлүүлэх замаар ордын үнэ цэнийг өсгөх, ажлын байрыг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, татвар хураамж орлогыг нэмэгдүүлэхэд энэхүү үйлдвэрийг ашиглалтад оруулах нь чухал юм.

Таван толгой нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл энэ сард хэлэлцэн баталсан бөгөөд энэ оны 7 дугаар сард багтаан төслийн урьдчилсан зураг төслийг хийж дуусгахаар төлөвлөжээ. Тус үйлдвэр нь тус бүр 10 сая тн/жил хүчин чадал бүхий 3 блокоос бүрдэх бөгөөд үйлдвэрийн бүрэн хүчин чадал нь 30 сая тн/ жил байх юм. Төслийн нийт өртөг 911.53 сая ам.доллар, хөрөнгө оруулалтаа 7 жилийн дотор нөхөх өндөр үр өгөөжтэй гэж үзэж байна.

Үйлдвэрт Тавантолгойн ордын коксжих, сул коксжих нүүрсийг баяжуулж, хатуу коксжих нүүрсний баяжмал, хагас

зөөлөн коксжих нүүрсний баяжмал, мидлингийг гаргаж, дэлхийн зах зээлд нийлүүлнэ. Нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор 1000 орчим ажлын байр шинээр бий болж, улсын болон орон нутгийн төсөвт 208.45 сая ам.долларыг төвлөрүүлэх боломжтой аж.

ТОВЧООР

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаар Сангийн сайд танилцуулав. Хөтөлбөрийн хүрээнд нийт 56 арга хэмжээ авч хэрэгжүүлэх бөгөөд үүнээс 25 арга хэмжээг энэ онд, 3 арга хэмжээг 2021-2022 онд, 17 арга хэмжээг 2021-2024 онд, 11 арга хэмжээг халдвар тархалтын шаталсан түвшин, нөхцөл байдлаас хамаарч тухай бүр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Ажлын байрыг дэмжих зорилтын хүрээнд энэ сарын 26-ны өдрийн байдлаар 604.2 тэрбум төгрөгийг 8.784 зээлдэгчид олгоод байна.

-Коронавируст халдвар/КОВИД-19-ын талаар хийж буй судалгааны төслийн ажлын талаар Эрүүл мэндийн сайд танилцуулав. Энэ чиглэлээр 2020-2021 онд нийт 14 судалгаа хийж байна.

-Жендерийн Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталлаа. Тус хороонд зарим холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг нэмэв. Мөн Жендерийн Үндэсний хорооны дэргэд жендерийн эрх тэгш байдлыг хангах хөгжлийн бодлогын үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэхэд стратегийн дэмжлэг үзүүлэх, зөвлөх чиг үүрэгтэй Бодлогын зөвлөл ажиллаж болсон юм.

Д.Ганзориг: ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧДЫН ТӨЛӨВШИЛ САЛБАРЫН ОФИЦЕРУУДААС ИХЭЭХЭН ХАМААРНА

(Түүрүүч нь I нүүрт)

Рот /батареи/, салааны захирагч гэдэг Зэвсэгт хүчний хамгийн эрхэм бөгөөд хүндтэй ажил. Цэргийн жинхэнэ алба хаахаар ирсэн олон аавын хүүг удирдан чиглүүлдэг энэ ажлыг сайн гүйцэтгэж чадвал сайн офицер болж чаддаг. Би ч гэсэн та нар шиг салааны захирагчаас ажлын гараагаа эхэлж байлаа. Ажил хийхэд алдаа, оноо гаралгүй яах вэ. Миний бие та нар шиг залуухан офицер явахдаа сургалтынхаа төлөвлөгөөг зөрчөөд хугацаат цэргийн алба хаагчдаа биеийн тамирын хичээл орууллаа гэж шийтгүүлж л явсан. Гэхдээ энэ нь алдаа гаргаж болно гэсэн үг биш. Аль болох алдаа гаргахгүйн төлөө явах ёстойг илэрхийлж байгаа юм. Өнөөдөр бид нэг зүйлийг сайтар ойлгох хэрэгтэй. Офицер, ахлагчийн мэргэжлийн ур чадвар, хандлага, үүрэг гүйцэтгэлтээс Зэвсэгт хүчний хөгжил, дэвшил шууд хамааралтай. Түүний нэг нь манай бүтээлч хандлагатай, хөдөлмөрч офицер, ахлагч нарын ачаар зэвсэглэл, цэргийн техникийн сэргээн сайжруулалт өнгөрсөн оноос бодит ажил хэрэг боллоо. Даян дэлхийн энхийг сахиулах үйлсэд монгол цэргүүд өнөөх

л янзаараа шалгарч, дэлхийн орнуудын Зэвсэгт хүчнээс өндөр үнэлгээ авсан хэвээрээ байна. Улс орныхоо бүтээн байгуулалтыг нуруун дээрээ үүрч, төмөр замын ажлыг богино хугацаанд чанартайгаар гүйцэтгэж байна гээд амжилтуудаа тоочвол бишгүй бий. Гэхдээ бид амжилтаас илүү алдаа, оноондоо дүгнэлт хийж, ярилцах ёстой. Энэ зөвлөгөөний зорилго ч үүнд оршиж байгаа юм” гэв. Үргэлжлүүлэн рот, салааны захирагч нарын заавал мөрдөж ажиллах зарчмын талаар ярилла. Тухайлбал, “Хугацаат цэргийн алба хаагчидтай зөвхөн Цэргийн нийтлэг дүрмийн хүрээнд харилц. Цэргийн ёсоор захирч, хүний ёсоор хайрлаж, хүнлэг энэрэнгүй бай. Салааны бүрэлдэхүүнээ тодорхой хугацааны дараа ямар амжилтад хүрсэн байхыг урьдчилан харж, төлөвлө. Ингэхдээ заавал биелэгдэх боломжтой үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь хангуул. Өөртөө итгэх итгэлийг нь бий болгож, албандаа дасах, албаараа бахархах үзлийг нь нэмэгдүүл. Хугацаат цэргийн алба хаахын ач холбогдлыг сэтгэл зүйд нь ойгуулаагүй бол шилдэг дайчин тодорч гарахгүй. Сэтгэл зүйн хичээлийг өдөр бүр оруул. Даарсан ч

даараагүй юм шиг, өлссөн ч өлсөөгүй юм шиг, эх оронч үзэл, хүмүүжилтэй, зөв төлөвшилтэй, хат суусан сэтгэл зүйг дайчдаа төлөвшүүлж чаддаг бай. Хоёрдугаарт, та рот, салааны захирагч бол сайн сэтгэл зүйч байх хэрэгтэй. Тухайн хугацаат цэргийн алба хаагчийнхаа нутаг ус, гэр бүлийнх нь байдлаас гадна хүсэл мөрөөдөл, зорилго тэмүүлэлийг нь мэддэг бай. Хүсэл мөрөөдлийг нь хурцалж, урам өгдөг ухуулагч бай. Гуравдугаарт, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд социологийн судалгаандаа дүн шинжилгээ хийж, алдаа дутагдал байвал хүлээн зөвшөөрч, засаж чаддаг байх хэрэгтэй. Алдаагаа хүлээн зөвшөөрч чадахгүй яваад байвал том асуудалд хүргэх эрсдэл байдгийг та бид санаж байх хэрэгтэй. Дөрөвдүгээрт, өөрийгөө хөгжүүлж, чадваржуулахад анхаар. Сайн удирдагч л сайн мэргэжлтийг бий болгож, хүмүүжүүлдэг юм. Улс орныхоо батлан хамгаалахын чадавхыг нэмэгдүүлэхэд рот, салааны захирагч та нарын үүрэг асар их шүү” гээд тэдний цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт хүсч, зөвлөгөөндөө идэвх санаачилгатай оролцохыг захилаа.

ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН НЭГТГЭЛ, АНГИУДЫН УДИРДЛАГА ЦАХИМААР ХУРАЛДАВ



Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, хурандаа Б.Баатар өчигдөр Тусгай хүчний цэргийн нэгтгэл, ангиудын удирдлага болон рот /батареи/, салааны захирагч нарт цахимаар хуралдаж тодорхой чиглэлээр үүрэг, даалгавар өгсөн юм.

Тэрээр “Энэ удаагийн зөвлөгөөнөөр та бүхэн нийгэмд эзлэх байр суурь, хүлээх үүрэг, хариуцлага илүү ихээр ухамсарлаж, зөв төлөвшил, зөв хүмүүжил, зөв чиг хандлагыг урьтал болгон, багаар ажиллах чадварыг эзэмшихийн ач холбогдлыг ойлгоно гэдэгт итгэж байна. Сүүлийн үед Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн алба, сахилга, зохион байгуулалтыг дээшлүүлэх, гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаар зөвлөмж, сэрэмжлүүлэг, албан даалгавруудыг тогтмол хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж байгаа боловч хувь хүний албандаа хандах хандлага, төлөвлөөс шалтгаалсан хэрэг зөрчил гарсан. Үүнийг цэргийн алба хаагчийн хүмүүжил, төлөвшил, албандаа хандах хандлагатай холбож үзэхээс аргагүй.

Тусгай хүчний цэргийн командлагчийн хувиар та бүхэнд анхаарах хэд хэдэн асуудлаар үүрэг өгье. Нэгдүгээрт цэргийн алба, сахилга хариуцлага дээшлүүл. Тусгай хүчний цэрэг гэдэг гадаад өнгө үзэмж, эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилтээрээ бусад нөхдөө манлайлагч нь байх ёстой. Яагаад та нарыг тусгай хүчний

цэрэг гэж нэрлэсэн юм бэ. Энэ том “малгай”-гаа ухамсарлаж, үлгэр жишээ цэргийн алба хаагч байхад яг одооноос анхаар. Алдаа дутагдал байгаа бол түүнийг зас, өөрийгөө хөгжүүл. Хоёрдугаарт, сэтгэл зүйн бэлтгэл, ёс суртахууны өндөр боловсролтой байх хэрэгтэй. Цэргийн алба гэдэг хамгийн шилдэг залуусын цугласан салбар. Энд сахилга, хариуцлага, ёс зүйн доголдолтой нэг ч хүн байж болохгүй. Таны гүйцэтгэж байгаа үүрэг, гаргаж байгаа хандлагаас эх орон, Зэвсэгт хүчний нэр хүнд хамаарч байдгийг ямагт санах хэрэгтэй. Гуравдугаарт, цэргийн сургалт бэлтгэлээ сайжруул. 2020-2021 оны сургуулийн жилийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөндөө тодотгол хийж, өөрийн ангийн онцлог, чиг үүрэгт тохирсон сургалтыг нэмэгдүүл. Тусгай хүчний цэргийн сургалтын стандарт, журам, төлөвлөгөө тун удахгүй батлагдана. Тусгай хүчний цэргийн алба хаагч та тэрхүү стандарт, шаардлагад нийцсэн сургалтыг зохион байгуулах ёстой. Дөрөвдүгээрт, долоо хоногийн товч,



өдөр тутмын цагийн хуваарийг ягтал мөрдөж ажилла. Цагийн хуваарийг зөрчснөөс үүдээд алдаа дутагдал гардаг гэдгийг сайн ойлгох хэрэгтэй” гээд цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарч ажиллахыг даалгасан юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

ЦАХИМ ШУУДАНД

ҮЛГЭРЛЭЛ ЗӨВ ХАРАГДВААС ХАНДЛАГА ЗӨВ ТОГТОНО



Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Рот /батареи/, салааны захирагч нартай “Зөв төлөвшил, зөв хүмүүжил” зөвлөгөөнд оролцохоор Дорноговь аймаг, Зүүнбаян тосгоноос ирсэн зөвдод ангийн захирагч, хурандаа А.Болдбаатар Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар товч танилцуулгыг хийснээр зөвлөгөөн эхэлсэн юм. Орон нутаг дахь ХЭҮК-ын ахлах шинжээч Ч.Нандин-Эрдэнэ “Зэвсэгт хүчин ба хүний эрх”, ГБХЗХГ-ын мэргэжилтэн Ц.Энхтунгалаг “Харилцаа ба хандлага”, Зүүнбаян нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч Ц.Болормаа “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах хэвшил”, Зүүнбаян тосгоны Ахмадын зөвлөлийн тэргүүлэгч Р.Хөхөө “Хугацаат цэргийн алба хаагчдыг соён гэгээрүүлэх арга зам, туршлага сургамж”, бэлтгэл хошууч Г.Хишигт “Эр цэрэг- эгэл амьдрал” сэдвээр танилцуулга хийж, мэдээлэл өглөө.

Үүний дараа зөвлөгөөний хөтөлбөрийн дагуу ангийн захирагчийн орлогч нар болон ангийн тэргүүн ахлагч, батальон, дивизоны захирагч, зарим офицерууд “Цэргийн алба хаагчдын ёс зүй, төлөвшил, тавигдаж буй шаардлага”, “Хүнтэй ажиллах арга барил”, “Ахлагчийн албаны байдал, цаашдын чиг хандлага”, “Цэргийн албанд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс, түүний үр дагавар”, “Гэр бүл төлөвлөлт, хувь хүний хандлага” сэдвээр яриа хийж, хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Салбарын офицеруудын цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, удирдан явуулах, заах арга зүйн төлөвшил, зөв хандлага, хүмүүжилтэй, иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн энэхүү хоёр өдрийн зөвлөгөөний дараа “Үлгэрлэл зөв харагдваас хандлага зөв тогтоно” гэсэн уриалга дэвшүүлж, төлөвлөгөө боловсруулж ажиллаж байна.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

"ЗӨВ ТӨЛӨВШИЛ, ЗӨВ ХҮМҮҮЖИЛ"



Зэвсэгт хүчний 065 дугаар анги

“Зөв төлөвшил, зөв хүмүүжил” сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж байна. Зөвлөгөөнд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн салаа, ротын захирагч нар болон түүнтэй адилтгах албан тушаалын 19 офицер халдвар хамгааллын дэглэмийг чандлан сахиж танхимаар, 11 салбарын нийт 47 офицер google-meet программ ашиглан цахим хэлбэрээр сургалтад хамрагдаж байна. Зөвлөгөөний нээлтийн үеэр ЗХЖШ-ын АЦК-ын Материал техникийн монгол хүн байхын учир”, “Цэргийн сургалт бэлтгэлд сургалтын шинэлэг арга, хэлбэр, технологийн дэвшил, шинэ бүтээл, оновчтой санал, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх арга зам”, “Цэргийн алба хаагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлүүд, тэдгээрийг бууруулах арга зам”, “Нийгмийн харилцаа ба цэргийн алба хаагчийн ёс зүй зэвсэглэл, цэргийн техникийн арчлан хамгаалалт, үзлэг явуулах журам, цэргийн алба хаагчийн хувцас, хүнсний нормт хангалт”, “Хүний эрх болон цэргийн алба хаагчдын



хэлтсийн дарга, хурандаа Г.Хашчулуун Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа болон Агаарын цэргийн командлалын цаашдын чиг хандлагын талаар танилцууллаа. Зөвлөгөөнийг “Монгол бахархал, хуулиар хязгаарласан эрхийн талаарх ойлголт”, “Офицер, ахлагчийн хувийн хүмүүжил, нэр хүндийн асуудал” зэрэг сэдвээр томилогдсон багш нар амжилттай зохион байгуулж байна.

Ахмад З.АНХБАЯР